

БАТЛАВ

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

ГАНХЖАРГАЛ

**ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ**

Хувилбар А

Хугацаа 80 минут

Нийт оноо 40

Нас... Нас... Нас...

/эсээ/

Саяхан надад ахимаг насны эмэгтэй жүжигчин “нас бол ердөө тоо” гэж хэлсэн юм. Бодоод л байлаа. Нас үнэхээр тоо, тоо, тоо... өөртөө шууд л итгүүлэхийг хүслээ. Гэвч таван настай жаахан охин минь төрсөн өдрөө дөхөхөөр хоног тоолдог шиг сүүлийн үед би ялгаагүй тийм болжээ. Чухам цаад учрыг нь сайн мэдэхгүй ч нэг нас нэмэх тоолонд дотроос минь хэн нэгэн өөдгүй этгээд “чи юу хийж амжуулав” хэмээн нэхэл хатуухан асуух болов. Эргэлзэж эхэллээ. Зарим хүмүүсийнхээр нас ердөө тоо л юм бол яагаад би шөнө нойр муутай бол маргааш нь тархи өдөржин дүйнгэ оргих болов. Өмнө нь хоёр өдрийн нойрыг огт тоодоггүй сэн. Үнэхээр зарим хүмүүсийнхээр нас ердөө ТОО юм бол яагаад миний шанаанд буурал үс нэмэгдэж, хөл гар өдрийн алхаандаа түүртэж өвдөг булчин халуу оргиод байх болов. Тэгэхээр биологийн амьдралын хувьд нас зүгээр хэдэн ТОО биш байх нь. Оюун санааны амьдралын хувьд өөр байж болох юм гэж найдах сэтгэл төрнө.

Харин ямар хүмүүс насыг зүгээр тоо гэж боддог вэ? Магадгүй ямар ч зорилгогүй явсан он жилүүдээ мартаж гэж ирээдүйд хийж бүтээх найдлага бий гэдэгт итгэж явдаг гэнэн хүмүүсийн бодол биз. Үгүй бол нэгэнт юу ч хийж бүтээж чадахгүй гэдгээ мэдчихээд өөрсдийгөө хуурах гэсэн харамсмаар оролдлого байхыг үгүйсгэхгүй. Нэг танил зохиолч минь 50 нас хүрээд хамгийн гол бүтээлээ бичнэ гэдэг юм. Тэр нь яруу найргийн бүтээл байх юм гэнэ лээ. Мэдээж хувь тавилан байвал түүний энэ мөрөөдөл биелнэ. Харин... дахиад л би өөрөө ч мэдэлгүй учир битүүлэг гурван цэг хаяж орхилоо. 50 нас оюун санааны байнгын бэлтгэл хийдэггүй, таван жилд яруу найргийн ганцхан жижиг ном хэвлүүлдэг ЗОХИОЛЧИД идэвхтэй оюуны амьдралын хувьд даанч өндөр нас. Тиймээс л би бүх эргэлзээ тээнэглэлээ гурван цэгэнд багтааж орхилоо.

Хэрэв хонин арц шиг 2000 жил, үгүй ядаж яст мэлхий 300 орчим жил насалдаг бол хүнд 50 жил хүүхэд нас л даа? Гэтэл харамсалтай нь тийм биш. Тэр тусмаа Монголд. Ар Кавказын ч юм уу Хятад, Афганистан хоёрын хил дээр оршдог уулын нэг тосгоныхон шиг 100 насалдаг бол бас асуудал өөр л дөө? Тэнд мэдээж цаг уурын таатай сайхан нөхцөл байдаг нь тодорхой. Уулын тунгалаг агаар. Харин энд бол миний хотын гоё саарал утаа, нүргээн, атаархал жөтөөрхлийн мананцар, уур бухимдал. Товчхондоо гадаад хэлний гайхамшигтай үг болох СТРЕСС ноёлно.

Дахиад л нас... нас... нас..гэсэн дарамттай үг тархин дотор минь үүрлэж, үл тайлагдах хүнд бодлууд зууралдана. Өнөөх өөдгүй этгээд сар өдрүүд хорогдох тусам “юу хийж амжуулав” хэмээн ам асууна. Тэгээд л түүнд хариулах юмтай байх гэсэн мэт чухам юунд шахагдаж хөөгдөөд байгаагаа мэдэхгүй тархи толгойгоо гашилган зүгээр суухгүйг хичээнэ.

Зохиолчид ихэвчлэн чононд зэрэгдэж хөөгдсөн хонь мэт амьдрах үйлд унасан байдаг. Яах гэж өдөрт гуравхан цаг унтаж, яах гэж амрах завгүй цаас цоохорлож,

ях гэж бусдын өмнөөс энэлэн шанална вэ? Энэ асуултад минь ханатал хариулах хүн одоохондоо миний амьдралд учраагүй л явна.

Шилэн дэлгүүрийн толин хананд алхаж яваагаа харахад хэдийнээ би ялимгүй бөгтийжээ. Харин оюун санааны хувьд...

П.Батхуяг

Эхэд ажиллах даалгавар

1. Тайлбарласан эсээнээс хөтөч өгүүлбэр болон зохиогчийн дүгнэлт өгүүлбэрийг ялган бичээрэй. \ 4 оноо \

Хөтөч

өгүүлбэр

.....
.....

Зохиогчийн дүгнэлт өгүүлбэр

2. "Тэгээд л түүнд хариулах юмтай байх гэсэн мэт чухам юунд шахагдаж хөөгдөөд байгаагаа мэдэхгүй тархи толгойгоо гашилган зүгээр суухгүйг хичээнэ." гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэр болгон хувиргаж бичээрэй. \ 4 оноо \

Нийлмэл өгүүлбэр

3. "Яах гэж өдөрт гуравхан цаг унтаж, яах гэж амрах завгүй цаас цоохорлож, яах гэж бусдын өмнөөс энэлэн шанална вэ? Гэсэн өгүүлбэрийн тодруулсан бүтээврийн утга, үүргийг тодорхойлж, адил утга үүрэг бүхий бүтээврээр солин найруулж бичээрэй. \ 4 оноо \

Бүтээврийн утга, үүрэг

Бүтээврийг солин найруулах

4. Дараах үгийг бүтээврээр задалж, зөв бичих дүрмийг бичээрэй. \ 2 оноо \

Зорилго –

5. Дараах үгийг бүтээврээр задалж, адил дүрмээр бичих 4 - үгийг эхээс олж бичээрэй.

\ 2 оноо \

амьдралын –

8. Шүлгийн хэсгээс цагийн байдалтай хүний сэтгэлийн өнгө аясыг хэрхэн холбосныг тайлбарлаарай. \ 2 оноо \

1..... Хээрийн галуу айлчлан ирж, гангар гунгар донгодохуйяа

Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна

Хажуу дахь уулд горхи булаг хоржигнон урсахуйяа

Хаяан дахь ишиг хурга майлалдан, хөгжим нийлүүлнэ

Дүрслэх ур маяг

Ямар ур маяг болох

9. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс” өгүүлэгийг дараах тодорхойлолтын дагуу ямар содон үйл явдлын утга учрыг нээсэн болохыг тодорхойлж бичээрэй. \ 2оноо\

Өгүүлэг нь хүний амьдралд тохиолдсон онцгой содон нэгэн хэрэг явдлын утга учрыг нээж харуулдаг.

10. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлж бичээрэй. \ 5 оноо\

ᠮᠠᠨᠢᠨ ᠭᠡᠨ ᠭᠡᠨᠭᠡᠢ . ᠮᠠᠨᠢᠨ ᠭᠡᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠭᠡᠨᠭᠡᠢ ..

ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

ᠨᠡᠳᠡ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ ᠮᠠᠨᠢᠨ

БАТЛАВ
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР ГАНХЖАРГАЛ

**ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ**

Хувилбар С

Хугацаа 80 минут

Нийт оноо 40

ААВЫН ҮГ, ХҮҮГИЙН ҮЙЛС

Цагийн хүүхэд төдийгүй, цаг яван одоход бодлоо үлдээж чадсан цагийг бүтээгч хөвгүүдийн нэгэн Лодон агсны хүү Түдэвийн тухай өнгөрснийг дурдатгал, эдүгээгийн бясалгалаар тодосгон байж энэхүү хөрөг нийтлэлийг бичсүү хэмээн зориглов.

Лодон гуай эргэж ирэхгүй аянд мордохоосоо хэдэн сарын өмнө “Би Чингисийн эр хоёр загал шиг хоёр хүүтэй явлаа. Багыг маань харийн орны Мушгиа голын лусын дагина тэвэрч аваад буцааж өгсөнгүй. Тавилан гэдэг энэ биз. Энэ Түдэв л одоо хоёр хүний хийхийг нэгэн биеэр үүрч, хоёр загалын явахыг нэгэн загалын хөлөөр туулах болжээ...” гэснийг нэхэн санав. Ингээд аавын үг, хүүгийн үйлс хоёр найрсан жигдэрч, эцгийн юу санасан есөн хүслийн манлай нь ёсоор бүтсэнсэн.

...Түдэв ажлын үеэр зохиол бичнэ гэж ер үгүй, зөвхөн оногдсон оногдсонд нь шууд хамаарах ажлаа л хийнэ. Хурдан, хальт мөлт болчих вий дээ гэмээр тун хурдан бичнэ. Баллана, сохолно гэж бараг үгүй. Үзэг нь дэгдэн гүйж, хар бэхийн нэг мөр нөгөө мөрөө дэрлэн ундрах нь горхи горхины бидэргээ адил хөвөрнө. Үүнд ер бусын хувилгаан чанар байхгүй ч ширээгдэж төрсөн номч мэргэнд заяадаг чанар буй. Үзэг нь бүдэрнэ ээ гэж үгүй.

Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном туурвиж, гучаад хэлээр нэг сая таван түмэн ширхэгээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил тийм ч байхаас яахан аж гэж бодогдоно.

Эхэд ажиллах даалгавар

1. Хөрөг найрууллын эхний цогцолборт буй “Энэ Түдэв л одоо хоёр хүний хийхийг нэгэн биеэр үүрч, хоёр загалын явахыг нэгэн загалын хөлөөр туулах болжээ...” гэснийг нэхэн санав. Ингээд аавын үг, хүүгийн үйлс хоёр найрсан жигдэрч, эцгийн юу санасан есөн хүслийн манлай нь ёсоор бүтсэнсэн. Гэсэн өгүүлбэрээс далд санааг илэрхийлсэн дүрслэлийг олж, далд санааг тайлбарлаарай. \ 4 оноо \

Дүрслэл

.....
.....
.....
.....
.....
.....
.....

8. Шүлгүүдийн хэсгийн уншаад зохиолч цаг улирлын байдалтай хүний сэтгэлийг холбож хэрхэн дү. \ 2 оноо \

- 1.Урьхан хонгор салхи өвс модыг намилзуулах дор
Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө
Шарласан модны навч хоёр нэгээр унах дор
Сэтгэлийн доторх уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно.

9 . Д.Нацагдорж “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгийн дараах хэсгийн хам сэдвийг

тодорхойлоорой. \ 2оноо\

Энгэр, нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмсөн, зүүн ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган, жолоо цулбуурыг хугас барин атгаад, баруун ханцуйгаа сул тавин, түүний дотор гараа нуун, ташаагаа тулж буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ.

10.Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлж бичээрэй.

بىيىن م ئامىم م بىيىم
بىيىن م بىيىن م بىيىن م
بىيىن م بىيىن م بىيىن م
بىيىن م بىيىن م بىيىن م
بىيىن م بىيىن م بىيىن م
بىيىن م بىيىن م بىيىن م